



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2003 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Ёс зүйн дүрэм батлах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 7.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг 2003 оны 1 дүгээр сард багтаан хэвлүүлж, төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагын ажилтнуудын хүртээл болгохыг Үндэсний аудитын газрын Тамгын хэлтэст даалгасугай.
3. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг ажилтнуудаараа судлуулж, мөрдөлтөд нь хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын хэлтсийн дарга, аймаг, нийслэлийн Ерөнхий аудиторуудад үүрэг болгосугай.



Л.ЖАВЗМАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2003
оны дугаар тушаалын хавсралт

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

УХА0122

1. Ерөнхий зүйл

1.1. Төрийн аудитын үйл ажиллагаанд хууль дээдлэх, шударга ёсыг хангах, бодитой байх зэрэг үндсэн зарчмуудыг ягштал мөрдүүлэх, төрийн аудитын хараат бус, найдвартай байдлыг хангуулах, төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг сонирхлын болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд энэхүү дүрмийн зорилго оршино. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг мөрдүүлэх нь төрийн аудитын байгууллагын ажилтнууд болон тэдний ажилд бусдын зүгээс итгэх итгэлийг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

1.2. Төрийн аудитын байгууллагын ажилтнууд төрийн албан хаагчдад тавигдах ёс суртахууны нийтлэг шаардлагаас гадна энэ дүрмийн 2 дугаар бүлэгт тодорхойлсон шаардлагуудыг хангаж ажиллах үүрэгтэй бөгөөд эдгээр шаардлагад үл нийцэх үйлдлийг ёс суртахууны зөрчил гэж үзнэ.

1.3. Төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм нь Үндэсний аудитын газар, аймаг, нийслэлийн аудитын газрын (цаашид “Төрийн аудитын байгууллага” гэх) Ерөнхий аудитор, удирдах, гүйцэтгэх ажилтан болон тус байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс (цаашид “Төрийн аудитын байгууллагын ажилтан” гэх)-т нэгэн адил хамаарна.

1.4. Төрийн аудитын байгууллагын ажилтан энэхүү дүрмийн шаардлагыг ягштал биелүүлж, албан үүргээ гүйцэтгэхдээ болон хувийн амьдралдаа ямар нэг зүй бус үйлдэл, ёс суртахуунгүй байдал гаргахгүй байж өөрийн буюу байгууллага, хамт олон, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалж байх үүрэгтэй. Энэ үүргээ хөсөрдүүлж, зөрчил гаргасан ажилтан өөрийгөө Төрийн аудитын байгууллагад ажиллах ёс суртахууны эрхгүй болж байна гэж ойлговол зохино.

1.5. Хяналт шалгалтын дээд байгууллагуудын олон улсын байгууллага ИНТОСАИ-гийн баталсан олон улсын аудиторуудын ёс суртахууны дүрмийг үндэслэн энэхүү дүрмийг боловсруулав.

2. Төрийн аудитын байгууллагын ажилтанд тавигдах шаардлагууд

2.1. Итгэл, найдвар хүлээх шаардлага

2.1.1. Төрийн аудитын байгууллага, түүний ажилтны ажил, аудитын дүн, санал дүгнэлт шударга, бодитой, алдаа мадаггүй гэдэгт УИХ, Засгийн газар, шалгагдсан байгууллага, олон нийт итгэлтэй байх нөхцлийг хангахын хамт тэдний арга ажиллагаа аливаа хардлага сэрглэг, шүүмжлэлд өртөхгүй байх шаардлагатай.

1.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан удирдах, удирдуулах ёс, төрийн албаны дүрэм журмыг чанд сахин, бие биенээ харилцан хүндэтгэж, өөр хоорондоо нөхөрсөг, шударга, хамтаж, ажил хэрэгч харилцаатай байна. Бусад ажилтны аудитын дүн, дүгнэлтэд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно. Төрийн аудитын байгууллагын ажилтан удирдах ажилтны хуульд нийцсэн шийдвэр, үндэслэл бүхий төвлөмжийг биелүүлэх үүрэгтэй.

2.2. Шударга ёсыг сахих шаардлага

2.2.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэх, шалгагдагч байгууллагын ажилтан, холбогдох бусад этгээдтэй харилцахдаа шулуун шударга, бодитой хандаж, зан харилцаа, ёс суртахууны болон мэргэжлийн өндөр шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй. Бусдыг басамжлах, нэр төрийг нь путаан доромжлох, дарамт шахалт үзүүлэх, чирэгдүүлэх, хүнд суртал гаргахыг хориглоно.

2.2.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан ямарваа шийдвэр гаргахдаа улс үндэстний эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьж байх ёстой.

2.2.3. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэх, Төрийн аудитын байгууллагын хөрөнгө нөөцийг ашиглахдаа туйлын үнэнч шударга хандах ёстойн зэрэгцээ дараахь зүйлийг цээрлэнэ:

- 1) аудитыг хүндэтгэх шалтгаангүй дутуу дулимаг хийх, шалгагдагч байгууллага, хүмүүстэй хуйвалдах, ая тал засах, төлбөр, зөрчил, түүний шалтгаан нөхцөл, гэм буруутай этгээдийг нуун дарагдуулах, дутагдлыг хаацайлах,
- 2) төрийн аудитын байгууллагын эд хогшил, техник хэрэгсэл, хөрөнгө мөнгө, баримт материал, мэдээлэл, тамга, тэмдэг, албан бичиг, акт, албан шаардлагын хэвлэмэл хуудсыг албаны бус зорилгоор ашиглах, хуурамчаар бичиг баримт үйлдэх, тодорхойлолт, баталгаа гаргах,
- 3) хууль бусаар ашиг орлого олох, орлогоо нуух, татвар төлөхөөс зайлсхийх.

2.2.4. Төрийн аудитын байгууллагын шугамаар бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд оролцох ажилтнуудад дараахь зүйлийг хориглоно:

- 1) гэрээлэгч болон түүнтэй өрсөлдөгч этгээдээс мөнгө, шан харамж, үнэ бүхий зүйл авах,
- 2) албан ёсоор зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд өмч хөрөнгө болон эх үүсвэр сонгохтой холбоотой аливаа мэдээлэл тараах,
- 3) гэрээлэгч, түүнтэй өрсөлдөгч этгээдээс ажил, албан тушаал гүйж туслалцаа хүсэх, санал болгосон ажил, албан тушаалыг нь хүлээн зөвшөөрөх.

2.2.5. Энэ дүрмийн 2.2.4-т дурдсан бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд оролцох гэдэгт дараахь үйл ажиллагааг хамааруулж ойлгоно:

- 1) худалдан авах үйл ажиллагааг хянах, батламжлах,
- 2) худалдан авах бүтээгдэхүүн, бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тодорхойлолт, санал боловсруулах,
- 3) тэрээ контрактын төсөл боловсруулах,
- 4) тэрээлэгчдийг сонгох болон үнэлэх,
- 5) тэрээ байгуулах болон тендерт шалгаруулж эрх олгох.

2.3. Хараат бус байдлыг хангах шаардлага

2.3.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан шалгагдагч байгууллага болон холбогдох бусад этгээдээс хараат бус байх ёстай. Үүний тулд хараат бус байдлыг супруулж болзошгүй хувийн болон гадны хүчин зүйлсээс зайлсхийх шаардлагатай.

2.3.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан шалгаж буй асуудал, аудитын тайландаа бодитой хандах шаардлагатай бөгөөд аудитын дүгнэлт гагцхүү төрийн хийн шалгалтын стандартын дагуу олж цуглуулсан нотлох зүйлд тулгуурласан байвал зохино.

2.3.3. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан тушаалын бүрэн эрхээ хөрөгжүүлсний төлөө шалгагдагч байгууллага, холбогдох бусад этгээдээс мөнгөн үнэ цэн бүхий бэлэг, дурсгалын зүйл, шан харамж авах, өөртөө болон гэр бүл, ах дүү, төрөл садандаа үнэгүй буюу хөнгөлттэй үйлчлүүлэхээс татгалзах замаар сонирхлын болзошгүй зөрчлөөс зайлсхийж, хараат бус байдлаа хамгаалах ёстай. Шалгагдагч байгууллага, холбогдох бусад этгээд гэдэгт юуны өмнө Засгийн газартай бизнесийн ба санхүүгийн харилцаа тогтоохыг эрмэлзэж буй этгээд, төрийн аудитын байгууллагын шалгалтаас хамаарч ашиг сонирхол нь ихээхэн хондогдеж болох этгээд, төрийн аудитын байгууллагаар үйл ажиллагаа нь шалгагддаг этгээдийг хамааруулан ойлгоно.

2.3.4. Дараахь тохиолдолд дор дурдсан зүйлийг хүлээн авч болно:

- 1) Аудитын холбогдолтой уулзалт, ярилцлага хийх, томилолтоор ажиллах явцад цай, кофегоор дайлсан тохиолдолд,
- 2) Байгууллагын нэр, эмблем бүхий танилцуулга, үзэг, харандаа, дэвтэр, хуанли зэрэг сурталчилгааны материал.

2.3.5. Хэрэв төрийн аудитын байгууллагын ажилтан бусад байгууллагаас ажил эрэлхийлж байгаа бол энэ тухай байгууллагынхаа удирдлагад мэдэгдэх ёстай. Ажилд орох сонирхолтой байгууллагадаа аудит хийж, тэднээс ажил, албан тушаал түйж болохгүй. Энэ тухай мэдээлэл авсан удирдах ажилтан аудитын хараат бус байдлыг алдагдуулахгүйн үүднээс уг ажилтныг ажил эрэлхийлж буй байгууллагад нь аудит хийлгэхгүй байх арга хэмжээ авна.

2.3.6. Төрийн аудитын байгууллагын ажилтан хувийн сонирхол болон төрийн байгууллагын чиг үүргийн хооронд зөрчил үүсгэх нөхцөл байдалд оролцохгүй байх

хувийн тухайлбал, дараахь нөхцөл байдал нь сонирхлын зөрчил үүсгэх тул
ийнхийн шаардлагатай:

- 1) төрийн албыг хувийн ашиг сонирхолд ашиглах,
- 2) албан нэг этгээдэд бусдаас илүү хандаж давуу тал олгох,
- 3) үр ашигтүй, үрэлгэн үйл ажиллагаа явуулах,
- 4) албан ёсны шийдвэрийг тогтсон дүрэм журам зөрчиж гаргах,
- 5) хараат бус байдал, бодитой хандах чадвараа алдах,
- 6) төр, засгийн байгууллага, түүний үйл ажиллагааны шударга байдалд олон түмний итгэх итгэлийг хөсөрдүүлэх.

2.3.7. Хэрэв иймэрхүү нөхцөл байдал үүсвэл Төрийн аудитын байгууллагын төрбөгдх албан тушаалтанд мэдэгдэх бөгөөд байгууллагын удирдлага аудитын цэрвант бус байдлыг алдагдуулахгүй байх арга хэмжээ авна.

2.3.8. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ үр дүнтэй, бүрэн дүүрэн гүйцэтгэхэд нь харшлах өөр ажил, үйл ажиллагааг цалинтай, цалингүй төрбөрээр ажлаас гадуур гүйцэтгэж болохгүй.

2.3.9. Төрийн аудитын байгууллагын ажилтан санхүүгийн болон санхүүгийн бус сонирхол бүхий байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаанд аудит хийхэд оролцож болохгүй. Санхүүгийн болон санхүүгийн бус сонирхол гэдэг нь өргөн хүрээтэй ойнголт бөгөөд түүний дотор дараахь нөхцөл байдал хамарагдана:

- 1) аж ахуйн нэгж, байгууллагын хувьцаа эзэмшигч нь байх,
- 2) тухайн байгууллагаас ямар нэгэн төрлийн цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж авдаг байх,
- 3) тухайн байгууллагын үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан, түүнээсээ орлого олдог байх,
- 4) эхнэр, нөхөр, хүүхэд нь тухайн байгууллагад ажилладаг байх,
- 5) тухайн байгууллагад ажилтан, захирал, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, зөвлөгчөөр давхар ажилладаг байх.

2.3.10. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан тушаалаа хувийн зорилгоор төвлөглих, авилгалын эрсдэл бүхий аливаа харилцаанаас зайлсхийн шаардлагатай.

2.3.11. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэхдээ архи, согтууруулах ундаа хэрэглэх, шалгагдагч байгууллагын ажилтнуудаар зочлуулж дайлуулах, зугаа цэнгээний арга хэмжээнд нь оролцохыг хориглоно.

5.4 Улс төрийн хувьд төвийг сахих шаардлага

5.4.1 Төрийн аудитын байгууллага, түүний ажилтан чиг үүргээ шулуун шударгаа төрөлжүүлэхийн тулд улс төрийн нөлөөнөөс хараат бус байж, улс төрийн хувьд төвийг сахина.

5.4.2 Улс төрийн үйл ажиллагаанд оролцох нь тэдний хараат бус байдал, бодитой ондах чадвар, олон нийтийн итгэл найдварт сөргөөр нөлөөлж, мэргэжлийн хувьд төрлийд хүргэнэ гэдгийг төрийн аудитын байгууллагын ажилтан ухамсарласан тийшээл зохино.

5.5 Мэдээллийн нууцыг хамгаалах шаардлага

5.5.1 Төрийн аудитын байгууллагын ажилтан аудитын явцад олж авсан мэдээллийг төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэхээс ширүүлж боломж юу болохгүй.

5.5.2 Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцад олж авсан мэдээллийг хувийн буюу бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, мэдээллийг задалж зарим байгууллага, хүмүүст шударга бус, хэт давуу байдал олж, бусдын эсрэг ашиглах боломж юу болохгүй.

5.5.3 Төрийн аудитын байгууллагын ажилтан аудитын холбогдолтой асуудлыг дуусаагүй байхад олон нийтэд мэдээлэх, бүрэн бус мэдээлэлд тулгуурлан үзүүлжилсан дүгнэлт хийж байгууллага, хүмүүсийн нэр хүндэд сэв суулгах, аудитын явцад оөрт нь илэрхий болсон төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахыг бориглоно.

5.6 Хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд тавих шаардлага

5.6.1 Аудитын дүнгийн талаар уг аудитыг удирдаж хийлгэсэн ахлах албан тушаалтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр ярилцлага юу болно. Харин олон нийтийн дунд дуулиан дэгдээсэн, улс төржсөн эмзэг асуудлаар зөвхөн байгууллагын удирдлага буюу эсвэл хэвлэлийн төлөөлөгч ярилцлага юу байх нь чадаатай.

5.6.2 Төрийн аудитын байгууллагын ажилтан мэргэжлийнхээ чиглэлээр хичээл залж, судалгаа шинжилгээ хийхээс бусад тохиолдолд байгууллагынхаа ажилтай холбоотой асуудлаар өгүүлэл бичсэн, уг хэлсэн, илтгэл тавьсны төлөө зохиогчийн шаардлагатай буюу эсвэл үнэ бүхий зүйл авч болохгүй. Хэлэх уг, нийтлүүлэх өгүүлэл нь Төрийн аудитын байгууллагын нэр хүнд, найдвартай байдалд харшилж болохгүй.

5.6.3 Дараахь асуудлаар уг хэлэх, өгүүлэл бэлтгэх ажилтан тухайн асуудлыг хариуцсан нэгжийн дарга, багийн ахлагчтай нь сайтар зөвшшилцэж нягталсан байх шаардлагатай:

- 1) Төрийн аудитын байгууллагад ажиллагсдын тухай,
- 2) Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тухай,

1) Төрийн аудитын байгууллагаар шалгагдсан байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаа, асуудлын тухай.

2) Дээр дурдсанаас бусад сэдвээр үг хэлэх, өгүүлэл бичих нь гадны ууцлагад давхар ажил, албан тушаал эрхлэхтэй адилд тооцогдох бөгөөд албан тушаалтнаас зөвшөөрөл авах шаардлагатай. Хэлэх үг, өгүүлэл зөвшөөрөл олгоходо тухайн мэдээллийг нийтэд түгээх нь төрийн аудитын байгууллагын болон улс үндэстний ашиг сонирхолд нийцэж буйж харгалзан үзнэ.

Мэргэжлийн шаардлага

1. Төрийн аудитын байгууллагын ажилтан байгууллагын зорилт, чиг үүргийг тажжуулэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байж, түүнийгээ сэлбэж, дээшлүүлж байх үүрэгтэй.

2. Төрийн аудитын байгууллагын ажилтан мэргэжлийн стандарт, дүрэм, мэддэг, тэдгээрийг мэдрдэг байх ёстой. Түүнчлэн шалгагдагч байгууллагын үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж, зохион байгуулалтын чиним, стандартуудын талаар сайтар ойлголт олж авах ёстой.

3. Төрийн аудитын байгууллагын ажилтан аудит хийхдээ хамгийн шилдэг арга хэмжээний ашиглана. Төрийн аудитын байгууллагын ажилтан аудит хийх болон тайлан боловсруулахдаа мэргэжлийн зохих ур дүй гаргаж хянамгай ажиллах шаардлагатай.

3. Дүрэм зөрчигчид хүлээлгэх хариуцлага

3.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан энэхүү дүрмийг чанд мөрдөх үүрэгтэй. Дүрмийн хэрэгжилтэд Төрийн аудитын байгууллагын удирдлага хяналт тавина.

3.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан ёс суртахууны зөрчил гаргасан тухай Мэдрэллийг Монгол Улсын болон аймаг, нийслэлийн Ерөнхий аудитор (цаашид "Ерөнхий аудитор" гэх) тусгай комисс томилж шалгуулна. Комиссын дарга, гишүүд шалгагдаж буй ажилтнаас хараат бус байх шаардлагатай.

3.3. Комисс шалгалтынхаа дүнг Ерөнхий аудиторт танилцуулна. Ерөнхий аудитор шалгалтын мөрөөр зохих арга хэмжээ авах, шаардлагатай гэж үзвэл шалгалтын дүн, авах арга хэмжээний саналыг удирдлагын зөвлөлийн гишүүдэд танилцуулж олонхийн саналаар шийдвэрлүүлж болно.

3.4. Ёс суртахууны зөрчил гаргасан нь тогтоогдсон ажилтанд зөрчлийн шинж байдлаас нь шалтгаалан Ерөнхий аудиторын тушаалаар:

- 1) сануулах,
- 2) сахилгын шийтгэл хүлээлгэх,

3) ажлаас халах

арга хэмжээний аль нэгийг авна.

1.6. Төрийн аудитын байгууллагын ажилтан ёс суртахууны зөрчил гаргасан тухай
мэдээлэл, түүнийг шалгаж тогтоохтой холбогдсон баримт материал байгууллагын
нууцад хамаарна.